

ТОЙМ



**ОЛОН УЛСЫН
ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**

2024.06.17

Голомт Капитал ҮЦК-д бэлтгэв

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- АНУ-н 5-р сарын инфляц хүлээлтээс бага буюу 3.3% гарлаа.
- ХНС-аас бодлогын хүүг хэвээр нь буюу 5.25-5.5 хооронд хадгалж, энэ онд 1 удаа бодлогын хүүг бууруулахаар болов.
- Технологийн салбарын компаниудын өсөлт индексийн өсөлтөд хүчтэй нөлөөлсөн хэвээр байгаа ч эсрэгээрээ аж үйлдвэрийн салбар өнгөрсөн сараас хойш уналттай хэвээр байна.
- БНХАУ-ын зах зээлийн голлох индексүүд болох Shanghai Composite Index 0.61%, Hang Seng индекс 2.31%-иар уналаа.
- БНХАУ-ын инфляцын түвшин хүлээлтээс доогуур өссөн буюу 0.3% өссөн бол үйлдвэрлэгчийн үнийн индекс 1.4%-иар буураад байна.

2024 он 6-р сарын 17

Dow Jones	38,589.16
S&P 500	5,431.60
Nasdaq	17,693.43
DAX	18,020.49
FTSE 100	8,146.86
S&P/ASX 200	7,724.30
HANG SENG	17,941.78

АНУ-ын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
Dow Jones	-0.15%	-0.72%	-3.54%	2.39%	12.51%	15.92%
S&P 500	-0.04%	1.32%	2.42%	13.87%	23.18%	30.37%
Nasdaq	0.15%	2.91%	6.04%	17.87%	29.25%	26.11%
2024 оны 6 сарын 17-ны 10:30						

Европын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
DAX	-1.34%	-2.57%	-3.66%	7.57%	10.17%	16.65%
FTSE 100	-0.21%	-0.99%	-3.25%	5.35%	6.60%	16.09%
2024 оны 6 сарын 17-ны 10:30						

Ази Номхон далайн индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
S&P/ASX 200	-0.19%	-1.87%	-1.29%	1.62%	6.37%	4.68%
Hang Seng	0.58%	-1.95%	-7.90%	5.64%	-10.14%	-37.47%
2024 оны 6 сарын 17-ны 10:30						





Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

АНУ-ын зах зээл технологийн компаниудаас шалтгаалан өсөлттэй байжээ.

S&P 500 болон NASDAQ 100 индексийн хувьд бүх цаг үеийн дээд ханшаа дахин шинэчлэн тогтоогоод байгаа ч аж үйлдвэрийн салбарын компаниудыг тодорхойлдог DJIA индекс уналттай байлаа. Apple компани хиймэл оюун ухаан хөгжүүлэгч OpenAI-тай хамтран ажиллахаар болсноор 2023 оны 4-р сараас хойш 164-200 үнийн хооронд арилжаалагдаж байсан бүсийг эвдэн 220 ам.доллар хүртэл өсөлтийг үзүүлээд байна. Цаашид ханш 230 ам.долларт хүрэх магадлалтай байна. Харин зах зээл дээр халуухан сэдэв болоод байгаа NVIDIA компани хувьцаагаа хувааснаас хойш 13 орчим хувийн өсөлтийг үзүүлэн дахин дээд ханшаа тогтоогоод байна.

Инфляц хүлээлтээс бага гарсан ч бодлогын хүүг хэвээр хадгаллаа.

Өнгөрсөн лхагва гарагт АНУ-ын 5-р сарын инфляцын мэдээ зарлагдаж хүлээлтээс бага буюу 3.3% болж буурсан нь сүүлийн 2 жилийн хугацаанд 5-р сард анх удаагаа тогтвортой байгаа явдал юм. Уг мэдэгдлийн дараагаар ХНС-ын ээлжит хурал болж бодлогын хүүгээ 5.25-5.5 хувийн хооронд хэвээр нь хадгална гэдгээ мэдэгдсэн бөгөөд инфляц буурах хандлага ажиглагдаж байгаа ч энэ нь хүүг бууруулах хангалттай шалтгаан болж өгөхгүй гэжээ.

Гэвч 2024 ондоо багтаан 1 удаа бодлогын хүүг бууруулахаар төлөвлөж байгаа ба гишүүдийн үзэж байгаагаар 4.9-5.1 хувь хүртэл бууруулахаар таамаглаж байна. Мөн Core (PPI) буюу үйлдвэрлэгчдийн үнийн индексийн мэдээ пүрэв гарагт зарлагдаж, хүлээлтээс бага буюу 2.3 хувь хүртэл буурч, 5 сар дараалсан өсөлтийг зогсоолоо. Үүнтэй холбоотойгоор 5-р сард импортын үнэ 0.4 хувиар буурсан нь сүүлийн 4-н сарын хугацаанд анхны бууралт болоод байгаа юм.

Аж үйлдвэрийн салбарын бизнесүүд царцаж байна.

Хэдийгээр инфляц бууран бодлогын хүүг хэвээр нь үлдээж, хөдөлмөрийн зах зээл зөөлөрч, ажилгүйдлийн түвшин 4 хувь хүртэл бага зэрэг өссөн зэрэг үзүүлэлтүүд байгаа нь зах зээл дээр аж үйлдвэрийн салбарын бизнесийн идэвхжил суларч эдийн засгийн царцсан байдлыг илтгэж байна. Гэсэн ч АНУ-ыг технологийн компаниудын хүчтэй өсөлт зах зээлийг аварсан хэвээр байна.

График 1: АНУ-ын S&P500 индекс ба Russell 2000-ийн корреляц 0.86 байдаг

stbllgoun published on TradingView.com, Jun 17, 2024 11:32 UTC+8

S&P 500 Index, 1D, CBOE 5,431.60 -2.14 (-0.04%)
RUSSELL 2000, 2,002.0 -30.4 (-1.50%)

Russell нь АНУ-ын 2000 компаниудыг багтаасан индекс бөгөөд S&P500 өсөж байхад Russell, Dow Jones унаж буй нь АНУ-ын технологийн салбараас бусад салбарын хувьцаанууд уналттай байгааг илтгэж байна.





Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

БНХАУ-ын зах зээл богино хугацаанд уналттай байгаа ч урт хугацаанд өсөлттэй байна

Өнгөрсөн долоо хоногт БНХАУ-ын зах зээлийн голлох индексүүд болох Shanghai Composite Index 0.61%, Hang Seng индекс 2.31%-иар уналаа.

Техник шинжилгээ:

- БНХАУ-ын зах зээл богино хугацаандаа унах магадлалтай ч урт хугацаандаа одоогийн цэгээс 16.3% өсөх боломжтой байна.
- Техник үзүүлэлтүүдийг хараад үзвэл Hang Seng индекс 18,275 нэгжийг доош сэтэлснээр богино хугацааны уналтын трендэд шилжсэн ба богино хугацааны уналтын тренд дуусахын тулд 18,735 цэгийг дээш давах шаардлагатай байна.
- Харин 2024 он гарснаас хойш дунд хугацааны өсөлтийн трендийг Hang Seng Индекс үзүүлээд байгаа бөгөөд 16,100 нэгжид унах хүртэл энэхүү трендээ хадгалах төлөвтэй байна. Ханшийн зорилт 20,885 нэгж буюу одоогийн түвшнээс 16.3%-ийн дээгүүр байгаа юм.

Зах зээл богино хугацаанд унасан шалтгаан:

БНХАУ-ын инфляцын түвшин хүлээлтээс доогуур өссөн буюу 0.3% өссөн нь төрөөс хэрэгжүүлж буй нь эрэлтийг дэмжих бодлоготой уялдахгүй байгаа юм. Түүнчлэн үйлдвэрлэгчийн үнийн индекс 1.4%-иар буурсан. Эдгээр үзүүлэлтүүд нь БНХАУ-д хэрэглэгчдийн итгэл сул байгааг илтгэж байна.

Аялал жуулчлалын орлого өсөлттэй байна:

Нөгөө талд БНХАУ-ын аялал жуулчлалын яамны мэдээллийг үзвэл өнгөрсөн 3 долоо хоногт аялал жуулчлалын орлого нэрлэсэн дүнгээр 8.1%-иар өссөн байна. Харин 2019 оны үетэй харьцуулахад жуулчдын зарцуулалт 12.3%-иар буурчээ.

График 2: Hang Seng индекс дэхь гол ажиглах ханшнууд

abillguun published on TradingView.com, Jun 17, 2024 13:25 UTC+8

Hang Seng Index, 1D, HSI O17,848.87 H18,122.80 L17,752.96 C17,975.67 +33.89 (+0.19%)



ТАЙЛАНГИЙН ХУАНЛИ

Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning June 10, 2024									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	
									
									
									
									
									
http://eps.sh/cal								© 2024 Earnings Whispers	

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning June 17, 2024									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	
									
									
									
									
									
									
									
									
									
									
http://eps.sh/cal								© 2024 Earnings Whispers	